



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЙГАЛЬ, ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2020 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН  
АУДИТ

АУДИТЫН КОД: БНА-2021/42/СТА-ТШЗ

Баянхонгор 2021 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576      Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням Утас: 99442140      Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор:                      П.Амаржаргал Утас:88106992      Цахим хаяг: amarjargalp@audit.gov.mn Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт /Эх хувь/ .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	11
3.Аудитын тайлан .....	11
3.1. Ерөнхий зүйл .....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	12
3.4. Материаллаг байдал .....	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	14
3.7. Шилэн дансны мэдээлэл .....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
3.9. Аудитын илрүүлэлт .....	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	16
Аудитын зөвлөмж .....	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	17
4. Менежментийн захидал.....	17
5. Хавсралт 1.: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	18



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail; bayankhongor@audit.gov.mn

Г БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ 7  
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Э.ГАНЗОРИГ ТАНАА

2021.02.25 № 2/203

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г **АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ** 7

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Аймгийн засаг дарга баталж, гүйцэтгэлийн тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

2021 А4 ТООТ

\* 005020103

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР Б.МӨНХБАТ



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>74,194,000.00</b>	<b>205,856,369.00</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	74,194,000.00	82,461,956.50
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	15,900,000.00	11,805,000.00
35110	Тусгай зориулалттай материал	15,900,000.00	11,805,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	57,994,000.00	70,656,956.50
35410	Бичиг хэргийн материал	592,500.00	200,000.00
35420	Аж ахуйн материал	23,168,500.00	21,403,960.00
35450	Барилгын засварын материал	00.00	320,000.00
35470	Бусад хангамжийн материал	34,233,000.00	48,732,996.50
35600	Мал амьтад	300,000.00	00.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	00.00	123,394,412.50
36100	Барааны нөөц	00.00	123,394,412.50
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>465,260,019.14</b>	<b>445,365,898.63</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	465,260,019.14	445,365,898.63
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	420,710,019.14	400,815,898.63
39201	Барилга, байгууламж, орон сууц	297,620,468.47	297,620,468.47
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-9,191,723.04
39203	Авто-тээврийн хэрэгсэл	154,568,890.00	108,110,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-68,222,778.94	-44,287,777.94
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	75,422,574.34	100,583,830.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-52,644,021.50	-68,110,868.89
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,689,567.00	21,511,080.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-2,847,678.23	-5,542,107.97
39217	Ном	122,998.00	122,998.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	44,550,000.00	44,550,000.00
39301	Программ хангамж	1,570,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,570,000.00	-770,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	44,550,000.00	44,550,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>539,454,019.14</b>	<b>651,222,267.63</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>539,454,019.14</b>	<b>651,222,267.63</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	539,454,019.14	651,222,267.63
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	252,228,714.62	252,228,714.62
51101	Өмч: - төрийн	252,228,714.62	252,228,714.62
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	94,506,378.77	206,274,627.26
51210	Өмнөх үеийн үр дүн	94,506,378.77	94,506,378.77
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	111,768,248.49
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	192,718,925.75	192,718,925.75
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>539,454,019.14</b>	<b>651,222,267.63</b>

Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>725,110,465.40</b>	<b>961,720,862.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,182,045.00</b>	<b>22,255,562.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>2,182,045.00</b>	<b>22,255,562.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,182,045.00	22,255,562.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	910,000.00	910,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,272,045.00	21,345,562.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>722,928,420.40</b>	<b>939,465,300.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>30,335,620.40</b>	<b>19,275,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,500,000.00	5,375,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	22,835,620.40	8,900,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>692,592,800.00</b>	<b>920,190,300.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	692,592,800.00	920,190,300.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>733,268,499.95</b>	<b>849,952,613.51</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>733,268,499.95</b>	<b>849,952,613.51</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>690,021,670.95</b>	<b>810,113,584.51</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>341,190,751.00</b>	<b>409,852,976.00</b>
210101	Үндсэн цалин	284,656,751.00	318,944,716.00
210102	Нэмэгдэл	39,859,600.00	53,962,146.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,674,400.00	33,385,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	3,561,114.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>41,593,698.00</b>	<b>50,639,839.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	41,593,698.00	50,178,439.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	461,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>16,420,171.00</b>	<b>16,916,096.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,937,956.00	1,871,573.00
210302	Түлш, халаалт	13,862,663.00	14,239,731.00
210303	Цэвэр, бохир ус	619,552.00	804,792.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>19,403,203.00</b>	<b>19,939,172.00</b>
210401	Бичиг хэрэг	3,539,700.00	4,551,300.00
210402	Тээвэр, шатахуун	12,375,445.00	11,068,962.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,186,658.00	2,295,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00	330,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	941,400.00	1,693,910.00
<b>2105</b>	<b>Нормативд зардал</b>	<b>5,280,000.00</b>	<b>4,925,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,280,000.00	4,925,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>7,890,500.00</b>	<b>5,201,900.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	50,000.00	76,500.00

**Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210604	Урсгал засвар	7,840,500.00	5,125,400.00
2107	Томилолт, зочны зардал	8,581,500.00	4,585,400.00
210702	Дотоод албан томилолт	8,581,500.00	4,585,400.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	210,606,420.40	197,601,051.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	209,132,720.40	195,002,351.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	150,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	1,900,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	298,500.00	298,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	217,000.00	72,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	480,000.00	00.00
210807	Газрын төлбөр	178,200.00	178,200.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	39,055,427.55	100,452,150.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	45,025,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	515,000.00	742,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	38,540,427.55	54,685,050.51
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	43,246,829.00	39,839,029.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	21,141,435.00	25,336,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,401,800.00	18,955,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,739,635.00	6,380,200.00
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	22,105,394.00	14,503,029.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,105,394.00	14,503,029.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-8,158,034.55</b>	<b>111,768,248.49</b>
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	50,000.08	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	50,000.08	00.00
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-50,000.08	00.00
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-8,208,034.63</b>	<b>111,768,248.49</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>723,870,117.40</b>	<b>940,375,300.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>910,000.00</b>	<b>910,000.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	910,000.00	910,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	910,000.00	910,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	910,000.00	910,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>722,960,117.40</b>	<b>939,465,300.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	30,335,620.40	19,275,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,500,000.00	5,375,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	22,835,620.40	8,900,000.00

**Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>692,592,800.00</b>	<b>920,190,300.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	692,592,800.00	920,190,300.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>31,697.00</b>	<b>00.00</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	31,697.00	00.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>691,135,117.40</b>	<b>926,284,370.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>691,135,117.40</b>	<b>926,284,370.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>647,856,591.40</b>	<b>884,445,341.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>341,268,163.00</b>	<b>409,327,395.00</b>
210101	Үндсэн цалин	284,734,163.00	318,944,716.00
210102	Нэмэгдэл	39,859,600.00	53,962,145.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,674,400.00	33,385,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	3,035,534.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>40,811,179.00</b>	<b>50,141,361.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	29,846,250.00	35,695,085.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,373,259.00	3,343,690.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,721,300.00	2,414,312.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	541,487.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,870,370.00	8,146,787.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>16,420,171.00</b>	<b>16,916,096.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,937,956.00	1,871,573.00
210302	Түлш, халаалт	13,862,663.00	14,239,731.00
210303	Цэвэр, бохир ус	619,552.00	804,792.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>15,742,858.00</b>	<b>18,493,700.00</b>
210401	Бичиг хэрэг	3,256,800.00	3,256,800.00
210402	Тээвэр, шатахуун	8,923,400.00	10,423,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,186,658.00	2,295,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00	360,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,016,000.00	2,158,500.00
<b>2105</b>	<b>Нормативд зардал</b>	<b>3,225,000.00</b>	<b>9,149,700.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	919,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,225,000.00	8,230,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,850,000.00</b>	<b>6,339,070.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	500,000.00	909,070.00
210604	Урсгал засвар	5,350,000.00	5,430,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>8,581,500.00</b>	<b>4,585,400.00</b>
210702	Дотоод албан томилолт	8,581,500.00	4,585,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>215,442,720.40</b>	<b>285,357,196.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	214,449,020.40	282,758,496.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	150,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	1,900,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	298,500.00	298,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	217,000.00	72,000.00
210807	Газрын төлбөр	178,200.00	178,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>515,000.00</b>	<b>84,135,423.00</b>

**Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	83,393,323.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	515,000.00	742,100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>43,278,526.00</b>	<b>41,839,029.00</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,173,132.00	27,336,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	31,697.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,401,800.00	18,955,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,739,635.00	8,380,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	22,105,394.00	14,503,029.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,105,394.00	14,503,029.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>32,735,000.00</b>	<b>14,090,930.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>32,735,000.00</b>	<b>14,090,930.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>32,735,000.00</b>	<b>14,090,930.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	32,735,000.00	14,090,930.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	32,735,000.00	14,090,930.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-32,735,000.00</b>	<b>-14,090,930.00</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	252,228,714.62	192,718,925.75	94,506,378.77	00.00	539,454,019.14
D01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	252,228,714.62	192,718,925.75	94,506,378.77	00.00	539,454,019.14
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин шилжүүлсэн үлдэгдэл	252,228,714.62	192,718,925.75	94,506,378.77	00.00	539,454,019.14
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	111,768,248.49	00.00	111,768,248.49
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	252,228,714.62	192,718,925.75	206,274,627.26	00.00	651,222,267.63

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	923,690,300.00	906,597,271.00	17,093,029.00	98.1
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	923,690,300.00	906,597,271.00	17,093,029.00	98.1
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	896,354,300.00	879,261,271.00	17,093,029.00	98.1
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	422,049,100.00	409,327,395.00	12,721,705.00	97.0

**Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210101	Үндсэн цалин	326,821,400.00	318,944,716.00	7,876,684.00	97.6
210102	Нэмэгдэл	58,135,200.00	53,962,145.00	4,173,055.00	92.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,396,000.00	33,385,000.00	11,000.00	100.0
210105	Гэрээт ажлын хөлс	3,696,500.00	3,035,534.00	660,966.00	82.1
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шнмтгэл</b>	<b>53,381,100.00</b>	<b>50,141,361.00</b>	<b>3,239,739.00</b>	<b>93.9</b>
210201	Тэтгэврийн даатгал	36,299,100.00	35,695,085.00	604,015.00	98.3
210202	Тэтгэмжийн даатгал	4,270,500.00	3,343,690.00	926,810.00	78.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,416,400.00	2,414,312.00	1,002,088.00	70.7
210204	Ажилгүйдлийн даатгал	854,100.00	541,487.00	312,613.00	63.4
210205	Эрүүл мэндийн даатгал	8,541,000.00	8,146,787.00	394,213.00	95.4
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>17,059,100.00</b>	<b>16,916,096.00</b>	<b>143,004.00</b>	<b>99.2</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,901,100.00	1,871,573.00	29,527.00	98.4
210302	Түлш, халаалт	14,256,200.00	14,239,731.00	16,469.00	99.9
210303	Цэвэр, бохир ус	901,800.00	804,792.00	97,008.00	89.2
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>18,493,700.00</b>	<b>18,493,700.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
210401	Бичиг хэрэг	3,256,800.00	3,256,800.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	10,423,400.00	10,423,400.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,295,000.00	2,295,000.00	0.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00	360,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,158,500.00	2,158,500.00	0.00	100.0
<b>2105</b>	<b>Нормативд зардал</b>	<b>9,149,700.00</b>	<b>9,149,700.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	919,700.00	919,700.00	0.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,230,000.00	8,230,000.00	0.00	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>20,430,000.00</b>	<b>20,430,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.00	10,000,000.00	0.00	100.0
210602	Тавилга	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	5,430,000.00	5,430,000.00	0.00	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,585,400.00</b>	<b>4,585,400.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
210702	Дотоод албан томилолт	4,585,400.00	4,585,400.00	0.00	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>267,019,100.00</b>	<b>266,082,196.00</b>	<b>936,904.00</b>	<b>99.6</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	264,420,400.00	263,483,496.00	936,904.00	99.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000.00	150,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,900,000.00	1,900,000.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	298,500.00	298,500.00	0.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	72,000.00	72,000.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	178,200.00	178,200.00	0.00	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>84,187,100.00</b>	<b>84,135,423.00</b>	<b>51,677.00</b>	<b>99.9</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	83,444,600.00	83,393,323.00	51,277.00	99.9

**Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	742,500.00	742,100.00	400.00	99.9
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	27336000.00	27336000.00	0.00	100.0
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	27,336,000.00	27,336,000.00	0.00	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,955,800.00	18,955,800.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,380,200.00	8,380,200.00	0.00	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	923,690,300.00	906,597,271.00	17,093,029.00	98.1
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	920,190,300.00	905,687,271.00	14,503,029.00	98.4
132001	Орон нутгийн төсвөөс	920,190,300.00	905,687,271.00	14,503,029.00	98.4
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	3,500,000.00	910,000.00	2,590,000.00	26.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,500,000.00	910,000.00	2,590,000.00	26.0
62	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	45.00	45.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	38.00	38.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	06.00	06.00	0.00	100.0

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>30335620.40</b>	<b>19,275,000.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>30335620.40</b>	<b>19,275,000.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	30335620.40	19,275,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30335620.40	19,275,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,335,620.40	19,275,000.00
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	30,335,620.40	19,275,000.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		19,275,000.00
131103	ЗГНХ,ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,500,000.00	5,375,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	22,835,620.40	8,900,000.00

**3. Аудитын тайлан**

**3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Ганзориг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн хадгалалт хамгаалалт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 24-өөс 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 104 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- “Байгаль орчин, аялал жуулчлалын хууль тогтоомжийг харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх, байгаль хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчин, аялал жуулчлалын мэдээллийн сан бүрдүүлэх, аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх, байгаль орчин, аялал жуулчлалын сургалт сурталчилгааны ажлыг гүйцэтгэхэд оршино” гэсэн зорилтын доор дараах чиг үүргийг хэрэгжүүлж ажилласан байна.

- Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, байгаль орчин, аялал жуулчлалын асуудал Засгийн газрын холбогдох агентлагууд, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бодлого, тогтоол, шийдвэр, үлгэрчилсэн дүрмийг удирдлага болгон Тусгай хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргаа, усны сав газрын Сав газрын захиргаа, аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэстэй ажлын уялдааг хангаж ажиллана.

- Газар нь аймгийн хэмжээний байгаль орчныг хамгаалах, ногоон хөгжлийг дэлгэрүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх, ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар тогтмол хангаж, хэрэглэгчдийг байгаль орчин, аялал жуулчлалтай холбогдолтой мэдээллээр хангах, экологийн боловсролыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль

### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2020 онд Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийсэн бөгөөд тухайн аудитын хугацаанд аудитын дүн тайланг гараагүй байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны 3 дугаар улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардал 664886.5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 13297.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 843163.5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 16863.3 мянган төгрөгөөр тооцов.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 651222.2 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 111768.1 мянган төгрөгөөр буюу 17.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, Засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>74,194.00</b>	<b>205,856.37</b>	<b>131,662.37</b>
Мөнгөн хөрөнгө	0	0	0.00
Авлага	0	0.00	0.00
Урьдчилгаа	0	0	0.00
Бараа материал	74,194.00	82,461.96	8,267.96
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>465,260.02</b>	<b>445,365.80</b>	<b>-19,894.22</b>
Үндсэн хөрөнгө	590,544.50	573,268.38	-17,276.12
Хуримтлагдсан элэгдэл	-38,540.43	-54,685.00	-16,144.57
Нийт хөрөнгө	539,454.02	651,222.20	111,768.18
Өр төлбөр	0	0	0.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	539,454.02	651,222.20	111,768.18
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	539,454.02	651,222.20	111,768.18

Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Өмнөх онд авлага дансны үлдэгдэл байхгүй байсан ба тайлант оны үйл ажиллагааг явуулахдаа хоорондын тооцоог бүрэн нийлж авлагыг бүрэн барагдуулж ажилласан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 82461.9 мянган төгрөг болж 8267.96 мянган төгрөгөөр өссөн нь 645.5 мянган төгрөгийн түлш шатах тослох материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, тайлант онд гэрээгээр гүйцэтгүүлсэн ажлуудаас Өргөөт рашааны тохижилтын 10000.0 мянган төгрөгийн ажил, Оготнотой булгийн тохижилтын 10000.0 мянган төгрөгийн ажил, Баянхонгор сумын айл өрхүүдэд Эко ариун цэврийн байгууламж барих 83714.4 мянган төгрөгийн, нийт 123394.4 мянган төгрөгийн ажлыг бараа материалын ИТХ-аас эзэмшигчийг тогтоож өгөөгүтэй холбоотой Нөөц дансанд бүртгэсэн, төсвийн хөрөнгөөр 85597.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020.07.30-ний 49 тоот тогтоолоор ашиглалтын шаардлага хангахгүй болсон 18858.9 мянган төгрөгийн бараа материал акталсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 573268.3 мянган төгрөг болж 17276.1 мянган төгрөгөөр буурсан нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020.07.30-ний 49 тоот тогтоолоор

**Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

ашиглалтын шаардлага хангахгүй болсон 52067.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь төсвийн хөрөнгөөр 9090.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 5000.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 20700 мянган төгрөгийн хаягдал хуванцар сав нягтруулан шахах төхөөрөмж дээд газрын хөрөнгө оруулалтаар ирснийг хүлээн авч дансанд бүртгэсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 651222.2 мянган төгрөг болж 111768.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 111768.1 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 961720.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 236610.3 мянган төгрөгөөр буюу 25 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 20073.5 мянга, тусламжийн орлого 216536.8 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн санхүүжилт 227597.5 мянга, засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс 5000.0 мянган төгрөгөөр өссөн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Нийт зардал 843163.4 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 109895.0 мянган төгрөгөөр буюу 13 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ, бараа үйлчилгээний бусад зардал нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 989075.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 989075.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 5259.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 994334.8 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр анх 994334.8 мянган төсөв батлагдаж 2020 оны 07-р сард тодотгол хийн 923690.3 мянган төгрөг болж 70644.5 мянган төгрөгөөр буурсан бол тайлант оны 12-р сарын байдлаар 920190.3 мянган төгрөгийн санхүүжилтээр, 3500.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 920190.3 мянга, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 3500.0 мянга нийт 923690.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 906597.2 мянган төгрөгийг зарцуулж 17093.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 906597.2 мянган төгрөг буюу 98.1 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 12721.5 мянга, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 3239.7 мянга, байр ашиглалттай холбоотой тогтол зардлыг 143.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийг 936.9 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 51.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 71413 хөтөлбөрийн 80101 арга хэмжээ 16104.8 мянга, 80205 арга хэмжээ 8.5 мянга, 80219 арга хэмжээ 927.9 мянга, 81701 арга хэмжээ 51.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хүснэгт.2 Төсвийн гүйцэтгэлийн тайлан /хөтөлбөр арга хэмжээгээр/						мянган.төг
№	ЭЗА	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ	ХУВЬ
<b>71413-Байгал орчин хамгаалан нөхөн сэргээх</b>						
<b>Нийт</b>			<b>923,690.30</b>	<b>906,597.27</b>	<b>17,093.03</b>	<b>98.1</b>
80101		Үндсэн үйл ажиллагааны зардал	548,489.30	532,384.45	16,104.85	97.1
1	210101	Үндсэн цалин	326,821.40	318,944.72	7,876.68	97.6
2	210102	Нэмэгдэл	58,135.20	53,962.15	4,173.06	92.8
3	210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,396.00	33,385.00	11.00	100.0
4	210105	Гэрээт ажлын цалин	3,696.50	3,035.53	660.97	82.1
5	210201	Нийгмийн даатгалын шимтгэл	36,299.10	35,695.09	604.01	98.3
6	210202	Тэтгэмжийн даатгал	4,270.50	3,343.69	926.81	78.3
7	210203	ҮОМШ-ний даатгал	3,416.40	2,414.31	1,002.09	70.7
8	210204	Ажилгүйдлийн даатгал	854.10	541.49	312.61	63.4
9	210205	Эрүүл мэндийн даатгал	8,541.00	8,146.79	394.21	95.4
10	210301	Гэрэл, цахилгаан	1,901.10	1,871.57	29.53	98.4
11	210302	Түлш, халаалт	14,256.20	14,239.73	16.47	99.9
12	210303	Цэвэр, бохир ус	901.80	804.79	97.01	89.2
13	210401	Бичиг хэрэг	3,256.80	3,256.80	0.00	100
14	210402	Тээвэр, шатахуун	10,423.40	10,423.40	0.00	100
15	210403	Шуудан, холбоо, интернэт	2,295.00	2,295.00	0.00	100
16	210405	Хог хаягдал зайлуулах, хортон	360.00	360.00	0.00	100
17	210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх,	2,158.50	2,158.50	0.00	100
18	210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	919.70	919.70	0.00	100
19	210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,230.00	8,230.00	0.00	100
20	210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000.00	10,000.00	0.00	100
21	210602	Тавилга	5,000.00	5,000.00	0.00	100
22	210604	Урсгал засвар	5,430.00	5,430.00	0.00	100
23	210702	Дотоод албан томилолт	4,585.40	4,585.40	0.00	100
24	210802	Аудит бат, зэрэглэл тогтоох	150.00	150.00	0.00	100
25	210803	Даатгалын Үйлчилгээ	1,900.00	1,900.00	0.00	100
26	210804	Тээврийн хэрэгслийн татвар	298.50	298.50	0.00	100
27	210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	72.00	72.00	0.00	100
28	210807	Газрын төлбөр	178.20	178.20	0.00	100
29	210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал	742.50	742.10	0.40	99.9
80205		Мэдээлэл, сурталчилгааны зарда	385.00	376.50	8.50	97.8
1	210801	Бусад нийтлэг АУТХураамж	385.00	376.50	8.50	97.8
80219		Харуул, хамгаалалтын зардал	6,480.00	5,552.03	927.97	85.7
1	210801	Бусад нийтлэг АУТХураамж	6,480.00	5,552.03	927.97	85.7
80802		Ажил олгогчоос олгох тэтгэмж,	27,336.00	27,336.00	0.00	100
1	213207	Тэтгэвэрт гарахад олгох тэтгэм	18,955.80	18,955.80	0.00	100
2	213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,380.20	8,380.20	0.00	100
81701		Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардал	341,000.00	340,948.29	51.71	100
1	210801	Бусад нийтлэг АУТХураамж	257,555.40	257,554.97	0.43	100
2	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	83,444.60	83,393.32	51.28	99.9

Эх сурвалж: Байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс Төрийн албан хаагчид олгох орон сууц, хашаа байшин худалдан авахад олгох тэтгэмж 5000.0 мянга, Э.Ганхуяг торгуулийн төлбөр 4600.0 мянга, БОАЖЯ-наас Говийн гайхамшиг-6 хөтөлбөрийн санхүүжилт 4300.0 мянга, хоггүй цэвэрхэн монгол аяны хүрээнд олон нийтэд мэдээ мэдээлэл хүргэх зардлын 70 хувь 3100.0 мянга, ногоон төгөл ногоон паспорт арчилгаа хамгаалалтын ажлын санхүүжилт 2275.0 мянган төгрөг нийт 19275.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж холбогдох зардалд зарцуулсан байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл мэдээлбэл зохих 149 мэдээллээс Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр),

Хүснэгт.2 Шилэн дансны мэдээлэл						
д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9		2
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	4		
4	Сар бүр	3	36	36		
5	Тухай бүр	8	96	86	10	
	Нийт	27	151	139	10	2

Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр) мэдээллийг 2,5-р сард 257338.4 мянган төгрөгийн 4 мэдээлэл, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр) 5-р сард 20776.0 мянган төгрөгийн 1 мэдээлэл, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр (Тухай бүр) мэдээллийг 2,4,5,8,12-р саруудад 5 мэдээлэл нийт 278114.4 мянган төгрөгийн 10 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 27929.5 мянган төгрөгийн зөрчлөөс 10129.5 мянган төгрөгийн зөрчлийг барагдуулах 1 албан шаардлага, алдаа дутагдлыг давтан гаргахгүй байх 17800.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	10129.5	1	10129.5			
Нийт дүн	1	10129.5	1	10129.5			

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 12822.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 6789.1 мянган төгрөгийн 1 алдаа залруулан, 1533.4 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 4500.0 мянган төгрөгийн зөрчилд 2 зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

#### Залруулсан алдаа

Үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцооллыг давтан шалгах явцад 2018 онд ашиглалтад орсон 5 нэрийн 70023.0 мянган төгрөгийн, 2020.02.20 -нд ашиглалтад орсон 20700,0 мянган төгрөгийн хөрөнгийн элэгдлийг бодуулаагүй байна. Элэгдлийн тооцооллыг тухайн байгууллагын ижил төстэй хөрөнгийн ашиглах хугацаагаар тооцож үзэхэд тайлант онд 6789.1 мянган төгрөгийн элэгдлийн зардал үр дүнгийн тайланд дутуу илэрхийлэгдсэн байна.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 6133.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрч 2 албан шаардлага, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийн өгөв. Үүнд:

1. Иргэн Э.Ганхуягт тогтоосон хууль бус ан агнуурын шүүхээр тогтоогдсон нөхөн төлбөрийн торгуулийн 4500.0 мянган төгрөгийг 2020.02.03-н өдөр тус байгууллагын 100030013405 тоот нэмэлт санхүүжилтийн дансанд тушаасныг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан "Байгаль орчин, уур амьсгалын санд оруулна" гэсэн хуулийн заалтыг зөрчин холбогдох албан тушаалтны шийдвэргүй зарцуулсан байна.

**Шийдвэрлэсэн нь:** Гаргасан алдааг залруулах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

2. Баян-Овоо сумын байгаль хамгаалагч О.Цэвээн нэхэмжлэгчтэй Аймгийн Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүгчийн 2019.11.29-ний өдрийн 131/ШЗ2019/02717 тоот захирамжаар ажлаас чөлөөлөгдсөн ажилтны цалингийн нөхөн олговорт 1400.4 мянган төгрөг, НДШ-д 133.0 мянган төгрөгийг олгоод буруутай албан тушаалтнаар төлүүлээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төрийн албан хаагчийн буруутай үйлдлийн улмаас төрд учруулсан хохирлыг барагдуулах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

#### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 4500.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Дараагийн аудитаар байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн зарцуулалтыг санхүүгийн тайлангийн аудитаар үзэх боломжгүй тул дараагийн аудитаар авч үзэх.

#### **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### **1. Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал**

**1.1 Илрүүлэлт:** Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл мэдээлбэл зохих 149 мэдээллээс 10 төрлийн 278114.4 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" 6.4 " Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалтыг зөрчсөн.

**1.2 Эрсдэл:** Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй байх.

**1.3 Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 ,дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" 6.4 " Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсний дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан бусад хяналт шалгалтын дүнг хугацаанд нь мэдээлж хуулийг хэрэгжүүлж ажиллах.

**1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### **АУДИТЫН ТАЙЛАНГ:**

Бэлтгэсэн:  
АУДИТОР

П.АМАРЖАРГАЛ 2021.02.25

Анхан шатанд хянасан:  
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЭНЯМ 2021.02.25

Хоёр дахь шатанд хянасан:  
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ 2021.02.25



**5. Хавсралт 1.: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо	Аудитын нэр:	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2020			БНА-2021/42/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:		Байгаль орчин, аялал жуулчлалын газар	Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Баян-Овоо сумын байгаль хамгаалагч О.Цэвээн нэхэмжлэгчтэй Аймгийн Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүгчийн 2019.11.29-ний өдрийн 131/ШЗ2019/02717 тоот захирамжаар ажлаас чөлөөлөгдсөн ажилтны цалингийн нөхөн олговорт 1400.4 мянган төгрөг, НДШ-д 133.0 мянган төгрөгийг олгоод буруутай албан тушаалтнаар төлүүлээгүй байна.	1533.4	Албан шаардлага өгсөн.	Дарга, нягтлан бодогч	Э.Ганзориг Т.Гантөмөр
2	Э.Ганхуягт Байгаль орчны хяналтын улсын байцаагч тогтоосон нөхөн төлбөрийн торгуулийн 4500.0 мянган төгрөгийг 2020.02.03-н өдөр тус байгууллагын 100030013405 тоот нэмэлт санхүүжилтийн дансанд тушаасныг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан "Байгаль орчин, уур амьсгалын санд оруулна" гэсэн хуулийн заалтыг зөрчин холбогдох албан тушаалтны шийдвэргүй зарцуулсан байна.	4600.0	Албан шаардлага өгсөн.	Дарга, нягтлан бодогч	Э.Ганзориг Т.Гантөмөр
3	Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл мэдээлбэл зохих 149 мэдээллээс тухай бүр мэдээлэх 10 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	0	Зөвлөмж өгсөн.	Дарга, нягтлан бодогч	Э.Ганзориг Т.Гантөмөр
<b>ДҮН</b>		<b>6133.4</b>			

оОо